

“Д.НАЦАГДОРЖ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ” сэдэвт эрдэм шинжилгээний хурал

Гомбосүрэнгийн Галбаяр
(МУИС-ийн ШУС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор)

“Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг их зохиолч Д.Нацагдорж (1906-1937)-ийн мэндэлсний 119 жилийн ойд зориулан, мэндэлсэн өдөр нь буюу 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 14:00-18:00 цагийн хооронд МУИС-ийн Эрдмийн өргөөнөө зохион байгуулав. Хурлыг Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэг, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхим хамтран зохион байгуулж, хуралдуулав. Хурлын урилга, хөтөлбөр нь;



Лавлах утас: (+976) 9918-1122
(+976) 9997-3349



“Д.НАЦАГДОРЖ СУДЛАЛЫН
ТУЛГАМДСАН АСУУДАЛ”
СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

УЛААНБААТАР ХОТ



УРИЛГА

Эрхэм хүндэт Таныг
Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдөрт
зориулсан “Д.НАЦАГДОРЖ СУДЛАЛЫН
ТУЛГАМДСАН АСУУДАЛ” сэдэвт эрдэм
шинжилгээний хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Зохион байгуулагч:

- Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэг;
- Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхим.

Хэргэ:

2025 оны 11 дүгээр сарын 17-ны 14:00-18:00 цагт

Хаяг:

МУИС-ийн Хичээлийн 1 байр. Эрдмийн танхим (Дугуй заал)

Хурал уяарлах:
МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор Г.Галбаяр
Хурлын хөтөлбөр:
14:00-14:45 Хурлын эхлэл:
МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн эрхлэгч, дэд профессор Б.Хингисүх
14:45-14:15 Мөнгөцгээх:
Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн тэргүүн, профессор К.Осика
МУИС-ийн ШУС-ийн захирал, профессор Ж.Болд-Эрдэнэ

Илтгэлч	Илтгэлийн сэдэв
1. 14:15-14:35 С.Байгасайхан (Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн дэд тэргүүн, Шинжлэх ухааны гавьяат гүйцэтгэл, профессор, доктор)	“Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудлууд”
2. 14:35-14:45 К.Осика (Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн тэргүүн, Японы Ганда Судлалын Их Сургуулийн хуучин профессор, доктор)	“Д.Нацагдоржийн “Ламбодын үгс”-ийг судлахад дүрмийн асуудлыг дахин авч үзэх нь”
3. 15:05-15:15 Ч.Жоши (Гавьяат багш, профессор, доктор)	“Д.Нацагдоржийн “Ламбодын үгс”-ийн дахь хэсгийн асуудлыг дахин авч үзэх нь”
4. 15:15-15:35 Асуулт, хариулт	
5. 15:35-15:45 Р.Чигтүвшин (МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн дэд профессор, доктор)	“Д.Нацагдоржийн “Ламбодын үгс”-ийн дахь хэсгийн асуудлыг дахин авч үзэх нь”
6. 16:05-16:15 Асуулт, хариулт	
7. 16:15-16:35 Б.Хингисүх (МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн дэд профессор, доктор)	“Д.Нацагдоржийн “Ламбодын үгс”-ийн дахь хэсгийн асуудлыг дахин авч үзэх нь”
8. 16:35-16:45 Асуулт, хариулт	
9. 16:45-17:05 Төгөөтү Байгаль (Япон улсын Оёри Их Сургуулийн профессор, доктор)	“Сайнхал болон Мисака улсын зохиолын харилцааг туршиг шинжлэх нь”
10. 17:05-17:15 Асуулт, хариулт	
11. 17:15-17:35 А.Монх-Орлов (МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн дэд профессор, доктор)	“Д.Нацагдоржийн “Ламбодын үгс”-ийн дахь хэсгийн асуудлыг дахин авч үзэх нь”
12. 17:35-17:45 Асуулт, хариулт	
13. 17:45-18:00 Хурлын таларх сэмтэлүүлэн, хурал хаах	

Хурал хаах: Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн дэд тэргүүн, профессор С.Байгасайхан

“Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн захирал, профессор Б.Болд-Эрдэнэ, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор багш нар, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн тэргүүн, Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн хүндэт профессор Казүюки Окада, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн дэд тэргүүн профессор С.Байгалсайхан, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, Япон улсын Хоккай Гакүэн Их Сургуулийн хүндэт профессор Айтору Тэлэнгүто, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн гишүүн, Япон улсын Оберин Их Сургуулийн профессор Төвчүүд Байгал нар болоод Монгол улсын Ардын уран зохиолч Ж.Саруулбуян, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, профессор Ч.Дагвадорж, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор Д.Цэнджав, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нямаа, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн О.Сундуй нарын тэргүүтэй зохиолчид, Монголын Зохиолчдын Эвлэлийн удирдах зөвлөлийн дарга, Монголын улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Ичинхорлоо тэргүүтэй Монголын Зохиолчдын Эвлэлийн удирдлагууд, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиол судлалын тасгийн эрхлэгч доктор Д.Цэвээндорж, профессор Г.Билгүүдэй, Д.Болормаа нарын зэрэг эрдэмтэд, МУБИС-ийн Утга зохиолын тэнхимийн эрхлэгч, доктор Б.Мөнхнаран нарын багш нар, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор Ж.Бат-Ирээдүй, Монгол улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн, орчуулагч Я.Ганбаатар тэргүүтэй хэлний шинжлэлийн эрдэмтэн мэргэд хийгээд утга зохиол судлалаар суралцаж байгаа докторант, магистрант, оюутнууд тус хуралд хүрэлцэн ирсэн байв.

Хурлыг хөтөлбөрийн дагуу МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор Г.Галбаяр удирдсан ба хурлыг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор Б.Хишигсүх нээж үг хэлэв. Профессор Б.Хишигсүхийн тус хурлыг нээж хэлсэн үг нь;

“Та бүхний амар амгаланг эрэн мэндчилж байна.

Монголын шинэ үеийн утга зохиолын үндэслэгчдийн нэг, суут зохиолч Дашидоржийн Нацагдоржийн мэндэлсний 119 жилийн ойн баярын мэндийг та бүхэнд хүргэж байна. Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн зүгээс МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхимтэй хамтран “Монголын уран зохиол судлал”-аар хэд хэдэн удаа хурал хийсэн. Тэдгээр хурлууд ч үүргээ биелүүлсэн. Тэдгээр хурлуудын уламжлалаар өнөөдөр их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан “Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал хийж байгааг албан ёсоор нээж байна. Ирэх жил Д.Нацагдоржийн мэндэлсний 120 жилийн тэгш ой болно. Тэр тэгш ойг угтан Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх, заримыг нь дараа жилийн ойд асуудал болгон тавихаар өнөөдрийн хурлыг хийж байгаад баяртай байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.”

Хурлын эхэнд хөтөлбөр ёсоор Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн тэргүүн, Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн хүндэт профессор Казүюки Окада мэндчилгээ дэвшүүлэв. Түүний дэвшүүлсэн мэндчилгээ нь;

“Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Миний бие Япон дахь Монголын Уран Зохиолын Нийгэмлэг (ЯдМУЗН)-ийн тэргүүн Казүюки Окада байна.

Их зохиолч Дашидоржийн Нацагдоржийн мэндэлсэн өдөрт зориулж, өнөөдөр ЯдМУЗН, Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн Шинжлэх ухааны сургууль (ШУС)-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхим хамтран зохион

байгуулж байгаа “Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд ЯдМУЗН-ийн нэрийн өмнөөс баярын мэндчилгээг дэвшүүлж байна. ЯдМУЗН бол өдгөөгөөс 50 гаруй жилийн тэртээ үүсч, үүссэн цагаасаа хойш монголын уран зохиолыг судлан шинжлэх, монголын уран зохиолыг япон уншигчдад хүргэх ажлыг тогтмол хийж байгаа байгууллага гэдгийг манай байгууллагыг мэдэхгүй зарим хүмүүст уламжилж байгаадаа таатай байна.

1906 оны 11-р сарын 17-нд мэндэлсэн Д.Нацагдоржийн 60 жилийн ойг 1966 онд Монгол улс даяар тэмдэглэсний дараа 1976, 1986, 1996, 2006, 2016 он гээд арван жил тутам өргөн дэлгэр тэмдэглэж ирсэн түүхтэй. Ирэх 2026 онд ч түүний мэндэлсний 120 жилийн ойг тохиолдуулж, нэлээд өргөн хүрээтэй арга хэмжээнүүд зохион байгуулагдана гэдэгт итгэж байна. Тийм учраас өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний хурал түүний мэндэлсний 119 жилийн ойг тэмдэглэж, улмаар дараа жил болох 120 жилийн ойг нь урьдчилан бэлгэдсэн сайхан арга хэмжээ гэж ойлгож ч болох юм.

Төрийн шагналт, Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнэ гуай одоогоос 50 гаруй жилийн өмнө буюу 1971 онд “Д.Нацагдоржийн өгүүллэгүүдийн талаар хийсэн судалгаа тун ч хомс шиг санагддаг” хэмээн харамслаа илэрхийлж байсан билээ. Харин Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, профессор Ч.Жачин багшийн 2018 онд эрхлэн хэвлүүлсэн “Д.Нацагдорж судлалын эрх” номыг лавлаж үзвэл “Д.Нацагдорж судлал” сүүлийн 50 гаруй жилд үсрэнгүй хөгжилд хүрснийг мэдэж болох бөгөөд цаашидаа ч хөгжинө гэдэгт итгэж болно байх.

За, эцэст нь их зохиолчийн мэндэлсэн өдөрт тохиолдуулан зохион байгуулсан “Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд болон мөн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэх эрдэмтэн багш нарт өндөр амжилт хүсье. Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.”

Мөн МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн захирал, профессор Б.Болд-Эрдэнэ мэндчилгээ дэвшүүлэв. Түүний мэндчилгээ нь доорх болно.

“Эрхэм хүндэт эрдэмтэн мэргэд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая!

МУИС нийгмийн олон салбараар сургалт, судалгааны ажил эрхэлдэг Монгол улсын ууган их сургууль билээ. Нийгмийн оюун санааны гол илэрхийлэх болох уран зохиолыг судлах, заан сургах ажлыг манай сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн ахмад багш нар болох Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ш.Гаадамба, С.Лувсанвандан, Ж.Бадраа, Д.Цэдэв, Ч.Дагвадорж, С.Дулам, Ч.Билигсайхан, Д.Галбаатар тэргүүтэй үе үеийн соён гэгээрүүлэгч, уран бүтээлч, эрдэмтэн багш нар эрхэлж байсан ба өдгөө тэдний шавь нар багшилж, судалгаа шинжилгээний ажлаа хийсээр байна.

Манай сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхим, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн хамт олонтой хамтран их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн ойд зориулан “Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт хурал хийж, ХХ зууны монголын их бичгийн хүн, шинэ цагийн монголын уран зохиолыг үндэслэгчдийн нэг Д.Нацагдоржийн намтар, уран бүтээлийг тал бүрээс нь судлан шинжилж хэлэлцэж байгаад талархан дэмжиж байна.

“Д.Нацагдорж судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурал өмнөө тавьсан зорилгоо биелүүлж, их зохиолч Д.Нацагдоржийн судлалд тодорхой ахиц дэвшил гаргаж, эрдэмтэн судлаачдын судалгаа мэргэн байна гэж итгэж байна. Цаашид монголын уран зохиолын нэрт төлөөлөгчдийн намтар, уран бүтээлийг судлан шинжилсэн хурлууд үргэлжилж, Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн эрдэмтэн судлаачид хамтран олон хурал хийнэ гэдэгт итгэж байна.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.”

Эхний илтгэлийг Шинжлэх Ухааны Гавьяат Зүтгэлтэн, Хэлбичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор С.Байгалсайхан “Д.НАЦАГДОРЖ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ” сэдвээр хэлэлцүүлэв. Энэ илтгэлд;

Д.Нацагдорж судлал хэрхэн үүссэн, үүссэн цагаасаа яаж хөгжих ирснийг 10-20 жилийн давтамжтай илтгэв. Энэ үечлэл бүхий давтамжуудын явцад Д.Нацагдорж судлал хэрхэн хөгжиж, тулгамдсан асуудлууд яаж шийдэгдэж ирснийг үе үеийн Д.Нацагдорж судлаачид (Б.Содном, Б.Ринчен, С.Лувсанвандан, Д.Цэдэв, Ч.Жачин зэрэг)-ын судалгаанд үндэслэж тайлбарлав. Түүний ажиглалтаар бол цаг хугацаа өнгөрөх тутам Д.Нацагдорж судлалын олон асуудал шинжлэх ухааны үндэслэлтэй шийдэгдэж ирсэн ч төдий чинээ ээдрээтэй, эргэлзээтэй асуудлууд урган гарч ирсээр байсан байна. Өөрөөр хэлбэл, Д.Нацагдорж судлалд шийдвэрлэх асуудлуудыг тухайн цаг үе бүрт Д.Нацагдорж судлаач эрдэмтэн мэргэд шийдвэрлэж ирсэн ч тэр шийдвэрүүдээс төдий чинээний эргэлзээтэй, цаашид судлах ёстой асуудлууд урган гарч ирсээр иржээ. Энэ нь өнөөгийн цаг үеэс харахад Д.Нацагдорж судлалд судлан шинжлүүштэй, тулгамдсан асуудлууд олон болсон ч нөгөө талаар судалж шийдвэрлэх тутам дараа дараагийн шинэ тулгамдсан асуудлууд урган гарч ирсээр байгаа нь Д.Нацагдоржийн сэтгэлгээ, туурвил зүйн гайхамшигт оршиж байна гэдгийг өгүүлэв. Нөгөө талаар Д.Нацагдорж судлалын түүхэн хөгжил хувьсал, ололт амжилт, алдаа мэдгийг тоймлон тодорхойлж, цаашид Д.Нацагдорж судлалд тулгамдсан асуудлуудыг дэвшүүлэн тавив. Тэр дундаа Д.Нацагдорж судлаач профессор Д.Цэдэвийн судалгаа шинжилгээний ололт амжилтыг түүний туурвисан Д.Нацагдорж судлалын өгүүллүүд, эх бичгийн судалгаа хийж, эрхлэн хэвлүүлсэн Д.Нацагдоржийн “Бүрэн түүвэр” (1996, 2006, 2016)-үүдийн баримтад тургуурлан дэлгэрэнгүй өгүүлэв.

Дараагийн илтгэлийг Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн тэргүүн, Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн хүндэт профессор Казүюки Окада “Д.НАЦАГДОРЖИЙН “ЛАМБУГАЙН НУЛИМС” ӨГҮҮЛЛЭГИЙН ДҮРИЙН АСУУДЛЫГ ДАХИН АВЧ ҮЗЭХ НЬ” сэдвээр хэлэлцүүлэв. Уг илтгэлд;

Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн тухай гарсан судлаач, уншигчдын дунд өрнөсөн маргаануудыг нэгтгэн судлаад “Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн Лодонгийн дүрийн тухай янз бүрийн тайлбар гарсаар байна. Энэ нь, тус зохиол мөнхөд амьдрах нууц, зөрчилт дүгнэлтэд хүргэх гайхамшигт увдистай болохыг илтгэн харуулж байна. Лодонгийн дүрийг эмгэнэлтэй, инээдэмтэй алин болох талаар уншигч, судлаачдын санал одоо ч нийлэхгүй байгаа нь үнэн боловч, миний бие ингэж бодож байна. Үүнд:

1. Энэ өгүүллэгийг хүний хувьд нь Лодонгийн “хайр дурлал”-ын явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл эмгэнэлтэй зохиол болно.

2. Энэ өгүүллэгийг лам санваартны хувьд нь Лодонгийн “завхай” явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл инээдэмтэй, шог хошин зохиол болно.

3. Энэ өгүүллэгийг зохиолч С.Эрдэнийн үзсэнээр Иүй Бай-хуа хэмээх Цэрэнлхамын “тачаангуй”, “зальтай” явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл, феодалын ялзарсан нийгмийг хурц шүүмжилсэн зохиол гэж болно.” гэсэн дүгнэлтэд хүрсэн илтгэлээ 1997 оны VIII сард Улаанбаатар хотноо хуралдсан Олон улсын монголч эрдэмтдийн VII их хурлын “Монголын утга зохиол, соёл, урлаг” хэмээх III салбар хуралдаанд “Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн дүрийн асуудалд” гэсэн нэртэйгээр хэлэлцүүлж, тус илтгэл-өгүүллээ 2002 онд Олон улсын

монгол судлалын холбоо (IAMS)-ны “MONGOLICA” цуврал бичгийн Vol.12 (33)-д хэвлүүлсэн ч И.Жавхлан зэрэг судлаачдын судалгаа хожим гарч, Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн талаарх өөрийн саналыг нэмэн дэлгэрүүлж, тайлбарлах шаардлага урган гарсан тул тус илтгэлдээ Д.Нацагдоржийн тус өгүүллэгийн талаарх саналаа дэлгэрүүлэн шинээр өгүүлсэн байна.

Гурав дахь илтгэлийг Монгол улсын Гавьяат багш, профессор Ч.Жачин “Д.НАЦАГДОРЖИЙН ЗОХИОЛЫН ГАР БИЧМЭЛ ДЭХ ҮГ СОЛБЖ, СОНГОСОН ЗАСВАРЫН ТУХАЙ” сэдвээр илтгэв. Илтгэлд;

Д.Нацагдорж зохиолоо их бодож, нягт нямбай бичдэг байсан нь түүний гар бичмэлүүдээс тодорхой харагддаг. Учир нь өөрийн бичсэн зүйлийг олон удаа засаж, засварладаг байсан байна. Энэ засварыг нэгд, өөрийн зохиолоо илүү сайн болгох зорилгоор, хоёрт, магадгүй тухайн үеийн нөхдөөс бичсэн зүйлээ тандан асууж, үзэл суртал, улс төрөөс болж засварладаг байх гэж таамагдаж байна. Мэдээж хэн ч өөрийн зохиолыг илүү сайн болгох зорилгоор засвар хийдэг байх. Өөрийн зохиолыг сайн болгох гэж дахин дахин уншиж, бодож боловсруулдаг байсныг нь харуулж байна. Нөгөө нэг хэсэг засварыг бол бүр баллаад, бүрэн дарчихсан байдаг. Ийм засваруудыг бол бидний зүгээс улс төр, үзэл суртал зэргээс үүдэж хийсэн байх гэж таамаглаж байна гээд ийм хоёр төрлийн засваруудыг хэрхэн судлан шинжилж ирсэн туршлага, өөрийн энэ судалгааны явцад оносон хийгээд алдсан зүйлүүдээ “Шувуун саарал”, “Харанхуй хад”, “Ламбугайн нулимс” өгүүллэгүүд, “Дөрвөн цаг”, “Хэвлэл” зэрэг шүлгүүдийн гар бичмэлүүдэд тулгуурлан дэлгэрэнгүй өгүүлэв.

Дөрөв дэх илтгэлийг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн зөвлөх профессор Р.Чүлтэмсүрэн “Д.НАЦАГДОРЖТОЙ ХОЛБООТОЙ АМАН ТҮҮХҮҮДИЙГ ЛАВШРУУЛАН СУДЛАХ НЬ” сэдвээр илтгэв. Илтгэлд;

Илтгэгч Д.Нацагдорж судлалд түүнтэй холбоотой аман түүх, мэдээ баримтууд чухал байр суурь эзэлдэгийг илэрхийлээд өөрийн багш, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш Д.Дашдорж гуайн сурвалжлан цуглуулж үлдээсэн Д.Нацагдоржийн тухай мэдээ мэдээлэл, баримт түүхүүдийг танилцуулж, тэдгээр аман хууч яриануудыг хэрхэн судлан шинжилж, Д.Нацагдорж судлалд хувь нэмэр оруулж байгаагаа өгүүлэв. Түүний илтгэснээр Д.Дашдорж багш Д.Нацагдорж зохиолчийн таньдаг, хамт ажиллаж байсан Б.Ринчен тэргүүтэй олон хүнээс асууж, бичүүлж авсан мэдээ баримтууд нэг хэсэг байдаг байна. Нөгөө нэг хэсэг нь Д.Нацагдоржийн танил байсан, найзалж нөхөрлөж явсан, бүр нутагт нь очиж, таних мэдэх хүмүүсээс нь түүний тухай яриулж, бичүүлж авсан хууч яриа, баримтууд байдаг байна. Эдгээр сонирхолтой хууч яриануудыг Д.Дашдорж багш сэрүүн тунгалаг ахуйдаа хэвлүүлсэн, судласан ч байдаг, судлаагүй, хэвлүүлээгүй үлдсэн зүйлсийг илтгэгчид өвлүүлэн үлдээсэн байдаг байна. Илтгэгч Д.Дашдорж багшийнхаа үлдээсэн Д.Нацагдоржийн тухай аман хууч яриануудыг цувралаар Д.Нацагдорж судлалын хурлууд дээр илтгэж, олны хүртээл болгож байгаа тухайгаа баримтат хууч яриануудад тулгуурлан илтгэв.

Тав дахь илтгэлийг Япон улсын Оберин Их Сургуулийн профессор Төвчүүд Байгал “САЙЧУНГА БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗОХИОЛЧДЫН ХАРИЛЦААГ ТУРШИН ШИНЖЛЭХ НЬ” сэдвээр илтгэв. Илтгэлд;

Сайчунга бол Өвөрмонголын орчин цагийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг гэдгийг өгүүлээд түүний уран бүтээлд Япон улсад суралцсан хийгээд Монгол улсад ажиллаж, амьдарч байсан нь гүнзгий нөлөөлсөн гэдгийг тойрч илтгэв. Сайчунга

Япон улсад суралцсанаар урлаг, уран зохиолын тухай онолын мэдлэг олж, дэлхийн сонгодог уран зохиолын туршлага, ололт амжилтаас суралцсан бол Монгол улсад ажиллаж, амьдарснаар уламжлалт монгол соёл, сэтгэлгээнээс гүнээ суралцаж, монгол зохиолчдын зохиол бүтээлийн туршлага, туурвил зүйгээс сайн суралцсан гэж танилцуулав. Монголын зохиолчдоос Д.Нацагдоржийн “Миний нутаг” тэргүүтэй зохиол бүтээл түүний урлан бүтээх аргад гүнзгий нөлөөлснийг хоёр зохиолчийн нэр бүхий шүлэг зохиолын мөр, бадгуудад тулгуурлан задлан шинжилснээ илтгэв.

Эхний таван илтгэлийн дараа Монгол улсын Ардын багш, профессор Л.Дашням, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч, сэтгүүлч Б.Галаарид, зохиолч Г.Батжаргал нар Д.Нацагдоржийн намтар судлал хийгээд хурлын илтгэлүүдтэй холбоотой үг хэлэв.

Эрдэмтэн зохиолч Л.Дашням “Өнөөдөр их зохиолч Д.Нацагдоржийн намтар, уран бүтээл дэх тулгамдсан асуудлуудаар мэргэжлийн эрдэмтэн, судлаачид хурал хийж, их зохиолчийн зохиол бүтээлүүдийг тойрч нарийн судалгааны зүйлүүд ярилцаж байгааг хараад талархаж сууна. Миний хувьд Д.Нацагдоржийн охин Анандатай сайн танил байсан. Түүнийг Монгол улсын иргэн болоход, улмаар Монгол улсын иргэн болоод Улаанбаатар хотод амьдарч байхад олон удаа уулзаж, өөрийнх нь болоод аав, ээж хоёрынх нь тухай дэлгэрэнгүй ярилцдаг байлаа. Нацагдоржийн Анандагийн тухай, түүний туурвисан шүлэг зохиолуудыг оруулаад “Хонгорхон хүмүүс” гэсэн ном хэвлүүлснийг та бүхэн уншсан байх. Яагаад үүнийг ярьж байна вэ гэвэл цаашид Д.Нацагдорж судлалтай холбоотой охиных нь амьдрал, үзэл баримтлал, шүлэг зохиолуудыг нь давхар судлавал зүгээр байх гэж бодсоных. Нөгөө талаар эхний 4 эрдэмтний илтгэл бүгд шинэ судалгаатай, асуудал дэвшүүлсэн сонирхолтой илтгэлүүд байна. Тэр дундаа сая илтгэсэн Японы судлаач Төвчүүд Байгалийн илтгэл их сонирхол татлаа. Учир нь Өвөрмонголын их зохиолч Сайчунгагийн монгол зохиолчидтой хэрхэн холбоо хамааралтай байсныг, тэр дундаа Д.Нацагдоржийн зохиол бүтээлээс Сайчунга хэрхэн уламжлал авч, өөрийн арга маягаар шинэчлэн туурвиж байсныг судлан тогтоосон нь сайхан санагдлаа. Ирэх жил их зохиолчийн маань 120 жилийн ой болно. Энэ тэгш ойн угтвар болгож, асуудлууд дэвшүүлсэн энэ хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье” хэмээв.

Зохиолч, сэтгүүлч Б.Галаарид “Өнөөдөр их зохиолчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулаад МУИС-ийн эрдмийн энэ өргөөнөө зохиолчид, уран зохиол судлаачид, уншигчид дүүрэн хуран цуглаж, их зохиолчийнхоо бүтээл туурвил, намтар түүхийн тухай шинэ судалгаанууд танилцуулагдаж, тэр судалгаануудаа тойрч ярилцаж байгаад баяртай байна. Д.Нацагдорж судлал цаг хугацаа өнгөрөх тутам улам тодорч, судлагдахуунууд улам олон болж байх шиг байна. Энэ нь Д.Нацагдоржийн билиг авьяас, түүний гэрэл гэгээний тусгал байх. Саяын илтгэсэн 4 илтгэл шинэ, сонирхолтой байлаа. Төвчүүд Байгал багш Өвөрмонголын их зохиолч Сайчунгагийнхаа бүтээл туурвил, сэтгэлгээ монголын зохиолчидтой, тэр дундаа Д.Нацагдоржийн уран бүтээлтэй хэрхэн холбоо хамааралтай болохыг нарийвчлан судалж, илтгэж байгааг сайшаан дэмжиж байна. Ингээд хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье” гэсэн товч үг хэлэв.

Зохиолч Г.Батжаргал “Сонирхолтой сайхан илтгэлүүд сонсоод талархаж байна. Миний хувьд зохиолч хүн юм. Саяхан нэг роман бичиж хэвлүүлээ. Энэ роман бол Д.Нацагдорж гуайтай холбоотой юм гэдгийг хэлэх гэж үг хэлж байна. Учир нь миний танил нэг хүний эгч нь Д.Нацагдорж зохиолчтой дотно үерхэж, түүгээр ч барахгүй хамтран амьрахаар тохиролцож байсан ч суугаагүй юм билээ. Тэр хүн Д.Нацагдоржийн тухай олон сонирхолтой хууч хөөрдөг байсныг би өөрийн энэ романдаа тусгасан.

Д.Нацагдоржтой холбоотой тэр сонирхолтой хуучуудыг энэ романаас уншиж болно гэдгийг та бүхэнд сонордуулья. Баярлалаа.” гэсэн үг хэлэв.

Зургаа дахь илтгэлийг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн дэд профессор Б.Хишигсүх “Д.НАЦАГДОРЖИЙН ХҮҮРНЭЛ ЗОХИОЛ ДАХЬ МОНГОЛЧУУДЫН СЭТГЭЛГЭЭНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ” сэдвээр илтгэв. Илтгэлд;

Монголчуудын сэтгэлгээний үнэт зүйлийг, нүүдэлчдийн сэтгэлгээний онцлог, нүүдэлчдийн аж төрөхүйн онцлог, нүүдэлчдийн нийгмийн байгуулалын онцлог, нүүдэлчдийн урлаг, гоо зүйн онцлогийг Д.Нацагдоржийн “Шувуун саарал”, “Хөдөө талын үзэсгэлэн”, “Цагаан сар ба хар нулимс” зэрэг өгүүллэг, “Учиртай гурван толгой” жүжгээр нь төлөөлүүлэн тайлбарлаж илтгэв. Мөн “Учиртай гурван толгой” жүжгийн Хоролмаагийн дүрийн урлалд гарсан ололтыг нийгэм цаг үе - хувь хүний үзэл баримтлал – хүний хайр сэтгэлийн холбоо хамаарал дунд нь авч үзэв.

Сүүлчийн илтгэлийг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн дэд профессор А.Мөнх-Оргил “Д.НАЦАГДОРЖИЙН “ЛАМБУГАЙН НУЛИМС”, С.ЭРДЭНИЙН “МАЛЫН ХӨЛИЙН ТООС” ӨГҮҮЛЛЭГҮҮД ДЭХ ДҮРСЛЭЛ, СЭТГЭЛГЭЭНИЙ УЛАМЖЛАЛ” сэдвээр илтгэв. Илтгэлд;

Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн дүрслэл, сэтгэлгээ, туурвилзүйн уламжлал орчин цагийн уран зохиол, жишээлбэл өгүүллэгийн төрөл зүйлд хэрхэн баяжиж ирснийг тодорхой жишээгээр авч үзэхийг зорьжээ. Уран сайхны харшууллын арга хоёр туйлыг нэг дор сөргүүлэн хандуулан гарцаагүй зөрчилд хүргэснээр нэгийг нь нөгөөгөөр нь нээх, мөн чанарыг нь илүү гүнзгий харуулах ингэснээр уншигчид цааш бодох, сэтгэх нээлттэй боломж олгодог. Тухайлбал өгүүллэгийн дүрслэл, сэтгэлгээ, уран сайхны аргын уламжлал 1960-аад оны өгүүллэгийн төрөл зүйлийн шинэчлэлийн төлөөлөгч болох С.Эрдэнийн “Малын хөлийн тоос” өгүүллэгт хэрхэн сонирхолтойгоор илэрснийг гол дүрийг харшуулсан дүрслэлээс тод харагддаг ажээ. Амьдралын үнэний хууль зүй, жам ёсыг хорь гучаад оны гэвш Лодонд дамнуурчны гудамнаа суух Иүй Бай-хуа амсуулж ойлгуулж өгч байгаа бол жараад оны эгэл бор Чанцалд тууварчин Балбар хэлж өгч байгаа юм. Ингэж хэлж ойлгуулж өгөхийн тулд тухайн нийгмийн хэв шинж болсон тэдгээр дүрийн үзэл санааг бүтээж босгох нь зөв сонголт болсон тухай тус хоёр өгүүллэгийг харьцуулан задлан тайлбарласан нь илтгэлийн онцлог болсон байна.

Илтгэгчид илтгэлүүдээ хэлэлцүүлсний дараа хуралд оролцогчид асуулт асууж, хариулт авав. Улмаар Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, доктор Д.Цэнджав “Хурал сайхан боллоо. Илтгэлүүд сонирхолтой, шинэлэг байлаа. Миний хувьд 3 зүйлийн товч санал хэлье. Нэгд, Д.Нацагдоржийн бүтээл туурвилуудыг ч нэлээд хэвлэж, хэлэлцэж байна. Цаашид Д.Нацагдорж судлалын бүтээлүүдийг иж бүрнээр нь хэвлэмээр байна. Үүн дээр анхаарцгаая. Хоёрт, Д.Нацагдорж судлалын дараа дараагийн хуралд шинэ залуу судлаачдыг татан оролцуулья. Өөрөөр хэлбэл, Д.Нацагдорж судлалын дараа үеийн эгнээг бэлтгэх нь зөв байх. Гуравт, Д.Нацагдоржийн амьдралын сүүлийн жилүүд, сэтгэл зүйг нь “Харанхуй хад” өгүүллэгтэй нь холбож судлавал шинэлэг байх болов уу гэсэн саналыг залуу судлаачдын сонорт хүргэе. Баярлалаа.” гэсэн үг хэлэв. Түүний дараагаар профессор Ж.Бат-Ирээдүй ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор О.Шинэбаяр тэргүүтэй судлаачид Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртсэн К.Окада багшид баяр хүргэж, бүтээл туурвилынхаа дээжээс илгээснийг гардуулан өгч, баяр хүргэв. Тэрбээр “Миний бие Герман улсад ажиллаж, амьдарч байхдаа Д.Нацагдоржийн намтартай холбоотой шинэ материал

олсон. Энэ хурлын хөтөлбөр гарсаны дараа хурлын тухай мэдээллийг олж мэдсэн учир тэр шинэ материалын тухай энэ хуралд хэлэлцүүлж чадсангүй. Дараа жил болох их зохиолчийн 120 жилийн хуралд шинэ мэдээ мэдээлэл бүхий илтгэл хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаагаа та бүхэнд дуулгая. Энэ хурлыг амжилттай сайн зохион байгуулж, хийсэн судлаачдад талархал илэрхийье.” гэсэн агуулгатай үг хэлсэн бол профессор Я.Ганбаатар “Сонирхолтой, зохион байгуулалт сайтай хуралд суусандаа таатай байна. Миний хувьд Д.Нацагдорж судлаач биш ч их зохиолчтой холбоотой 3,4 өгүүлэл бичиж хэвлүүлсэн хүн байгаа юм. Д.Нацагдорж Германд сурч байхдаа нэрт монголч эрдэмтэн Э.Хэйниш багшийн хажууд байж, түүнд тусалж байсан байдаг. Тэр утгаараа Э.Хэйниш багшийн номын сангаас Д.Нацагдоржтой холбоотой материалууд олддог, цаашид ч олдох байх. Мөн нөгөө талаар Д.Нацагдорж хятад хэлийг гайгүй сайн сурсан, тэр хэмжээгээрээ хятадын боловсрол, сэтгэлгээнээс суралцсан хүн гэж би үздэг. Энэ өнцгөөс нь цаашид судлах шаардлагатай байна гэдгийг судлаачдад уламжилъя.” гэсэн утгатай үг хэлэв. Дараагаар нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Т.Пүрэвсүрэн, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол хэл шинжлэлийн тэнхимийн багш, доктор Р.Сарангэрэл нар Д.Нацагдоржийн зохиолуудын үгийн сангийн толь хийж байгаагаа ярьж, Д.Нацагдорж судлаач С.Байгалсайхан, Ч.Жачин зэрэг хүмүүсээс арга зүйн зөвлөгөө авсанаар хурал өндөрлөв.

Хурлыг Япон дахь монголын уран зохиолын нийгэмлэгийн дэд тэргүүн, профессор С.Байгалсайхан хаав. Хурал хөтөлбөр ёсоор 18:00 цагт өндөрлөв.